



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/411

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Биеийн тамир спортын газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Монголын хүүхдийн спортын VII их наадамд Хөвсгөл аймгаас оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх зардалд 9,800.000 (есөн сая найман зуун мянга) төгрөгийг олгосугай.

2. Дээрх зардлын 9,800.000 (есөн сая найман зуун мянга) төгрөгийг 2023 оны төсөв нэмэгдүүлэх урсгал зардлын "Хүүхдийн спортын VII их наадамд оролцох баг тамирчдад дэмжлэг үзүүлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг Биеийн тамир спортын газрын дарга (Б.Очирбат)-д үүрэг болгосугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 07
дугаар сарын 27-ны өдрийн
А.Ч/1/ дугаар захирамжийн
хавсралт.

ХҮҮХДИЙН СПОРТЫН VII ИХ НААДАМД ОРОЛЦОХ БАГ
ТАМИРЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДАЛ

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Монголын хүүхдийн спортын VII их наадмын зардал	9,800,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	9,800,000	

_____оОо_____